

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын авто замын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/018/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СНАГ-2025/018/НА-СТА-ЗГТС



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.25 № 07/789
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын авто замын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,218,271.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс 55,245.6 мянган төгрөгийн өглөг, 350,738.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн;
- Тайлант хугацаанд хугацаа хэтрүүлсэн 407,908.3 мянган төгрөгийн гэрээт ажлын хугацаа хэтэрсэн алданги тооцоогүй, гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй, гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусгаагүй, ажлын гүйцэтгэл нь анхан шатны баримтаар баталгаажаагүй;
- Төлбөр хураах цэг нь нийт 119,446.9 мянган төгрөгийн төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүйгээр гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан;

- Тайлант онд худалдан авсан 270,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын авто замын сан тайлант онд төлбөр хураах үйл ажиллагаанаас нийт 28,665,223.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс 36,473,174.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгийн зардалд 51,915,426.6 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардалд 5,356,000.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,557,748.3 мянган төгрөг, өөрийн орлого 3,309,223.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/341 дүгээр тушаалаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2024 оны төлөвлөгөө"-г баталж тус төлөвлөгөөг 2024 оны А/171 дүгээр тушаалаар шинэчлэн нийт зардлыг 56,473,174.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудал

Улаанбаатар хот орчмын 6 төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг 2022 оны 10 сарны 22-ны өдөр мөн Дорноговь аймаг дахь Айраг, Замын-Үүд төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс бүрэн цахимжуулан авто зам ашигласны төлбөрийг тээврийн хэрэгслийн эзэмшигч дээр www.ezam.mn сайтаар дамжуулан нэхэмжлэх үүсгэн ажилласан байна. Цахим программ хангамжийг цаг тухай бүрт хөгжүүлэн, тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт төлбөр төлөх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, зам хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгахын тулд бүх банкны аппликейшн, цахим хэтэвч, цахим төлбөр тооцооны системийг хөгжүүлэн, И-Монголиа, И-баримт, ezam.mn, Гэрэгэ киоск, Кьюпэй, Токи, Мостмони эдгээр сайтуудтай хамтран ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,347,335,256.36	2,336,423,997.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	301,807,784.27	59,655,777.51
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	301,794,524.27	59,655,777.51
33	АВЛАГА	2,970,186.90	360,313,201.02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,970,186.90	9,575,022.12
33510	Байгууллагаас авах авлага	-	350,738,178.90
34	УРЬДЧИЛГАА	775,156,802.00	775,156,802.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,244,144.19	48,953,739.13
35400	Хангамжийн материал	64,244,144.19	48,953,739.13
35410	Бичиг хэргийн материал	8,681,926.99	6,540,539.93
35420	Аж ахуйн материал	807,600.00	570,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,005,300.00	6,461,500.00
35470	Бусад хангамжийн материал	49,749,317.20	35,381,699.20
360	Бусад эргэлтийн хөрөнгө	5,203,156,339.00	1,092,344,478.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	5,203,156,339.00	1,092,344,478.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,970,807,888.24	7,609,472,679.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,970,807,888.24	7,609,472,679.42
39200	Биет хөрөнгө	5,946,485,666.08	7,591,783,790.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,809,852,126.85	7,621,028,358.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(620,611,596.34)	(751,262,005.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	375,055,132.80	152,834,375.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(258,736,848.61)	(46,401,663.51)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,037,398,883.00	1,064,738,883.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(515,852,309.61)	(560,792,460.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	147,777,523.99	147,777,523.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,237,246.00)	(49,999,220.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,800,000.00	19,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,960,000.00)	(5,940,000.00)
39300	Биет бус хөрөнгө	24,322,222.16	17,688,888.80
39301	Програм хангамж	26,660,000.00	26,660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,498,888.92)	(17,815,555.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,900,000.00	19,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,738,888.92)	(11,055,555.60)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,318,143,144.60	9,945,896,677.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,141,638,670.16	202,532,774.51
41300	Өглөг	1,141,638,670.16	202,532,774.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,824,489.16	132,743,406.37
41360	Бусад өглөг	1,139,814,181.00	69,789,368.14
41361	Байгууллагад төлөх өглөг	1,139,514,181.00	69,789,368.14
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	300,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,176,504,474.44	9,743,363,902.57
51	Засгийн газрын хувь оролцоо	11,176,504,474.44	9,743,363,902.57
51200	Хуримтлагдсан үр дүн	10,791,953,117.43	9,358,812,545.56
51210	Өмнөх үеийн үр дүн	10,791,953,117.43	9,927,665,639.68
51220	Тайлант үеийн үр дүн		(568,853,094.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,551,357.01	384,551,357.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,318,143,144.60	9,945,896,677.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,470,113,806.89	60,618,713,607.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,996,938,906.89	28,703,287,012.57
120	Нийтлэг татварын бус орлого	23,996,938,906.89	28,703,287,012.57
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,996,938,906.89	28,665,223,398.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,870,614,213.16	28,665,223,398.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,836.84	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	126,203,856.89	-
120009	Бусад орлого		38,063,613.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,473,174,900.00	31,915,426,595.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36,473,174,900.00	31,915,426,595.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,473,174,900.00	31,915,426,595.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	59,717,073,287.66	61,195,266,701.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,574,235,265.76	9,279,840,106.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,455,856,290.14	5,798,160,707.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,569,038,795.53	3,719,751,259.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	449,972,513.99	461,090,006.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,481,428.34	171,784,359.27
2104	Хангамж, бараа материалын зардал	256,882,769.00	796,009,185.85
2105	Нормативт зардал	25,125,304.67	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,355,825.63	179,687,648.80
2107	Томилолт, зочны зардал	37,645,400.00	34,797,717.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	298,832,604.24	155,581,317.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394,521,648.74	279,459,213.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,378,975.62	3,481,679,398.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,363,142.00	22,910,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,015,833.62	3,458,769,398.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,015,833.62	3,309,223,398.85
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		149,546,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,142,838,021.90	51,915,426,595.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,142,838,021.90	51,915,426,595.00
223001	Бусад хөрөнгө	54,142,838,021.90	51,915,426,595.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	753,040,519.23	-(576,553,094.12)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	7,700,000.00
145003	Хөрөнгө оруулалтын олз	0	7,700,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0	7,700,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	753,040,519.23	(568,853,094.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	60,312,287,600.00	65,217,867,676.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,839,112,700.00	28,744,692,776.95
120	Нийтлэг татварын бус орлого	23,839,112,700.00	28,744,692,776.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,473,174,900.00	36,473,174,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,008,929,481.24	13,544,593,088.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,008,929,481.24	13,544,593,088.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,968,113,000.70	5,528,075,384.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,968,113,011.38	5,450,967,611.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,100.00	77,107,773.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,816,480.54	8,016,517,703.85
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55,303,358,118.76	51,673,274,588.244
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55,283,288,900.00	51,915,426,595.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(55,283,288,900.00)	(51,915,426,595.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,069,218.76	(242,152,006.76)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	281,738,542.45	301,807,784.27
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	301,807,784.27	59,655,777.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	384,551,357.01	10,038,912,598.64	10,423,463,955.65
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	384,551,357.01	10,038,912,598.64	10,423,463,955.65
9	Тайлант үеийн үр дүн	-	-	753,040,519.23	753,040,519.23
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	384,551,357.01	10,791,953,115.41	11,176,504,472.42
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(864,287,475.73)	(864,287,475.73)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		384,551,357.01	9,927,665,639.68	10,312,216,996.69
19	Тайлант үеийн үр дүн			(568,853,094.12)	(568,853,094.12)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		384,551,357.01	9,358,812,545.56	9,743,363,902.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,829,174,900.00	51,915,426,595.00	(9,913,748,305.00)	84
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,473,174,900.00	51,915,426,595.00	(4,557,748,305.00)	92
223001	Бусад хөрөнгө	56,473,174,900.00	51,915,426,595.00	(4,557,748,305.00)	92
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,829,174,000.00	60,580,649,093.85	(1,248,524,906.15)	98
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,473,174,000.00	31,915,425,695.00	(4,557,748,305.00)	88
310001	Улсын төсвөөс санхүүжих	36,473,174,000.00	31,915,425,695.00	(4,557,748,305.00)	88
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,356,000,000.00	28,665,223,398.85	3,309,223,398.85	113
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,356,000,000.00	28,665,223,398.85	3,309,223,398.85	113
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	285	231	54	81
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	0	100
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100
620004	Гэрээт ажилтан	275	221	54	80.4

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**3.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Аудитаар нийт 1,218,271.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 14,932.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,083,892.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 119,446.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/117 дугаар тушаалаар баталсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу 30 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээт ажлын гүйцэтгэлийн дагуу олгосон санхүүжилтээс нийт 4 гүйцэтгэгчид 680.6 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.	1	680.6	1	680.6				
2	Төлбөр хураах цэг нь автомашины 100км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж ажиллаагүйгээс нийт 7,461.8 мянган төгрөгийн шатахууны зардлыг илүү олгосон, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Жолоочийн тооцооны хуудас"-ыг хөтлөөгүй байна.	1	7,461.8	1	7,461.8				
3	Төлбөр хураах цэг нь Айраг төлбөр авах цэгт 2024 оны 11 дүгээр сард гарсан ослын торгууль 6,790.0 мянган төгрөгийн төлбөрийг авто замын сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.	1	6,790.0	1	6,790.0				
4	Тайлант онд дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд: 1. "Завхан АЗЗА" ТӨХК нь "Улсын чанартай авто замын дагуу авто зогсоол байгуулах ажлын гэрээ"-нд заасан "Улиастай-Алтай чиглэлийн авто замын дагуу байгуулах авто зогсоолын 1 дэх хэсэг" чиглэлийн 370,247.1 мянган төгрөгийн ажил, "Хөвсгөл зам" ХХК нь "Улсын чанартай авто замд тэмдэг, мэдээлэх самбар шинээр байршуулах ажлын гэрээ"-нд заасан "Мөрөн-Хатгал-Ханх-Улсын хил" чиглэлийн 22,294.0 мянган төгрөгийн ажлыг тус тус гүйцэтгээгүй байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, гэрээг цуцлаагүй; 2. "Улсын чанартай авто замд тэмдэг, мэдээлэх самбар шинээр байршуулах ажлын гэрээ" байгуулсан 9 компанийн 12 ажлын 7,666.2 мянган төгрөгийн алдангийг тооцоогүй; 3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/341 дүгээр тушаалаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын	1	407,908.3			1	407,908.3		

	<p>2024 оны төлөвлөгөө"-г баталсан бөгөөд 2024 оны A/117 дугаар тушаалаар төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна. Төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн дагуу "Завхан АЗЗА" ТӨХК, "Чандмань тал ХХК"-тай байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2024 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх гэрээ"-нд өөрчлөлт оруулаагүй;</p> <p>4. "Завхан АЗЗА" ТӨХК-д 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 507 дугаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2024 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний 7,701.0 мянган төгрөгийн ажлын санхүүжилтийг анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, тухайн ажлыг гүйцэтгэснийг нотлох ажлын тайлангүй олгосон байна.</p>								
5	<p>Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайланд онд дараах авлага, өр төлбөр үүсгэсэн байна Үүнд:</p> <p>1. "Ховд АЗЗА" ТӨХК-тай байгуулсан "Улсын чанартай авто замд ээлжит засварын ажил гүйцэтгэх гэрээ"-ний гүйцэтгэлээр гүйцэтгэгчид 729,030.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохдоо 350,738.2 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг суутгаагүй авлагаар бүртгэж тайлант хугацаанд авлага үүсгэсэн;</p> <p>2. "Дорноговь АЗЗА" ТӨХК-тай байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2024 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний гүйцэтгэлээс гүйцэтгэгчид 55,245.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олголгүй өглөг үүсгэсэн байна.</p>	1	405,983.8			1	405,983.8		
6	<p>Төлбөр хураах цэг нь нийт 119,446.9 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.</p>	1	119,446.9					1	119,446.9
7	<p>Өмнөх онд аудитаар өгсөн "Анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандах шийдвэрлүүлэх" зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд нэмэгдсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:</p> <p>1. "Хөх гол ус" ХХК-тай байгуулсан "Гадаргуун боловсруулалтын туршилт хийх лабораторийн багаж, тоног төхөөрөмж худалдан авах гэрээ"-ний дагуу хүлээн авсан 48,000.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг хөрөнгөд бүртгээгүй.</p> <p>2. "Мөнх буян агь" ХХК-тай байгуулсан "Төлбөр авах цэгийн автопүүний тохиргоо хийх эталон туухай бүхий тусгай зориулалтын автомашин худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авсан 222,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг хөрөнгөд бүртгээгүй.</p>	1	270,000.0			1	270,000.0		
	Дүн	7	1,218,271.4	3	14,932.4	3	1,083,892.1	1	119,446.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 55,695,755.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 38,930,170.4 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 16,765,585.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Улсын авто замын сан нь Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 4,752,382.3 мянган төгрөгийн 23 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6 тушаалыг шийдвэрийг мэдээлээгүй, 34,130,084.8 мянган төгрөгийн 208 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	38,882,467.1			1	38,882,467.1		
2	Төлбөр хураах цэг нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих 128 мэдээллээс 3 мэдээллийг мэдээлээгүй, 14 мэдээллийг дутуу, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10,926,481.6 мянган төгрөгийн 374 гүйлгээг хугацаа хоцроож, 1,763,731.6 мянган төгрөгийн 16 гүйлгээг мэдээлээгүй, 151,940.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн байна	1	12,842,154.1					1	12,842,154.1
Дүн		2	51,724,621.2			1	38,882,467.1	1	12,842,154.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Зам, тээврийн сайдын 2024 оны А/252 дугаар тушаалаар баталсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах хөрөнгийн жагсаалт"-ын дагуу 22 гүйцэтгэгчтэй байгуулсан 3,922,643.0 мянган төгрөгийн гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг тусгаагүй нь захиалагчийн гүйцэтгэгчид тавих хяналт болон гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээх үүргийг хянах, гэрээнд заасан алдангийг тооцох, гэрээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй нөхцөлийг бий болгосон байна.	1	3,922,643.0					1	3,922,643.0

2	“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс/ “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.6.2.3, 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төлбөр хураах цэгийн тоог нэмэгдүүлж, бүрэн цахимжуулах ажил, Засгийн 2022 оны 302 дугаар тогтоол"-ын хүрээнд мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх, нэвтрүүлэх, сурталчлах ажлыг багцалж тендер шалгаруулалт хийгээгүй, 3 компанитай шууд гэрээ байгуулсан, ижил төрлийн зардлыг хувь хүний дансанд шилжүүлж нийт 47,703.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	47,703.3			1	47,703.3		
3	Төлбөр хураах цэг нь тайлант хугацаанд Юнител компаниас А15 загварын гар утас 788.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Тухайн гар утасны ашиглалт хангалтгүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	788.0					1	788.0
	Дүн	3	3,971,134.3			1	47,703.3	2	3,923,431.0
	Нийт дүн	5	55,695,755.5			2	38,930,170.4	3	16,765,585.1